

- (1) Дахин нэвтрэх зөвшөөрөлтэйгээр хилээр гарсан хугацаанд оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан хүн,
 (2) Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа нь дууссан хүний оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдлийн тухай



2020 оны 6 сарын 26-ны өдөр
 (2022 оны 10 сарын 7-ны өдөр шинэчлэв)
 Хилийн шалган нэвтрүүлэх,
 оршин суух хяналтын газар
 Immigration Services Agency of Japan

Доорх (1) ба (2)-н дагуу бүрдүүлэх баримт бичгийг хялбаржуулна. Мөн, ердийн үеийнхээс илүү хурдан шалгана.

	(1) Дахин нэвтрэх зөвшөөрөлтэйгээр хилээр гарсан хугацаанд оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан хүн	(2) Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа нь дууссан хүн
Шаардаж нөхцөл	<ul style="list-style-type: none"> ○ Хилээр дахин орох, гарахаас өмнөх үйл ажиллагааны агуулга, оршин суух статус өөрчлөгдөөгүй хүн ○ Дахин нэвтрэх зөвшөөрөлтэй ба Япон улсад нэвтрэн орох хугацаа нь 2020 оны 1-р сарын 1 -ний өдрөөс 2023 оны 4-р сарын 30-ны өдөр дуусах хүн <p>(Анхаар 1) Оршин суух хугацаа дуусах хүртэл 1 сар орчим хугацаа үлдсэн хүн, энэ хугацаанд хилээр дахин орох найдваргүй хүн ч хамрагдана. (Анхаар 2) Дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл ч хамааралтай. (Анхаар 3) “Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн No.2” статусаар оршин сууж байсан хүн өмнөх ажилтай дүйцэх “Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн No.1” (イ, □, \-н аль нэг) статусын зөвшөөрөл авах өргөдөл гаргана уу.</p>	<ul style="list-style-type: none"> ○ Өмнөх мэдүүлгийн агуулгаас өөрчлөгдөөгүй хүн ※ Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ нь ихэвчлэн 3 сарын хугацаанд хүчинтэй байдаг бөгөөд тусгай заалтын хүрээнд, оршин суух зөвшөөрлийн гэрчилгээг олгосон хугацаанаас хамаарч, тус бүрийн хүчинтэй хугацааг тогтоосон. (Дэлгэрэнгүйг эндээс). <p>Энэ нь хүчинтэй хугацаа дууссан хүнд хамааралтай.</p> <p>(Анхаар) Хилээр орохоор төлөвлөсөн өдөр хүртэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусах магадлалтай хүн ч хамрагдана.</p>
Бүрдүүлэх материал	<ul style="list-style-type: none"> • Өргөдөл <ul style="list-style-type: none"> ※ Оршин суух статусын дагуух “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдөл”-г ашиглана уу. • Хүлээн авах байгууллагын учир шалтгааны тайлбар бичиг <ul style="list-style-type: none"> ※ Хавсаргасан лавлагааны маягт (Хавсралт 1, хавсралт 2)-н дагуу бичнэ үү. • Өмнөх оршин суух үнэмлэхийн хуулбар <ul style="list-style-type: none"> ※ Гадаад паспортын мэдээллээ өгөх боломжтой бол, зургаар эсвэл факсаар авсан хуулбар байж болно. Өгөх боломжгүй бол, үүний шалтгааныг бичсэн тайлбар (ямар ч формат байж болно)-аа ирүүлнэ үү. 	<ul style="list-style-type: none"> • Өргөдөл <ul style="list-style-type: none"> ※ Оршин суух статусын дагуух “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдөл”-г ашиглана уу. • Хүлээн авах байгууллагын учир шалтгааны тайлбар бичиг <ul style="list-style-type: none"> ※ Хавсаргасан лавлагааны маягт (Хавсралт 1, хавсралт 2)-н дагуу бичнэ үү. • Олгогдсон оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (Эх хувь эсвэл хуулбар) <ul style="list-style-type: none"> ※ Визийн мэдүүлэг өгөхөд оршин суух зөвшөөрлийн гэрчилгээг өгчихсөн гэх мэтийн шалтгаанаар хавсрах боломжгүй тохиолдолд үүний шалтгааныг бичсэн тайлбар (ямар ч формат байж болно) эсвэл визийн мэдүүлгийн өргөдлийн баталгаажуулсан хуудас(хуулбар)-ыг ирүүлнэ үү.
Мэдүүлэг өгөх хугацаа	<ul style="list-style-type: none"> • 2023 оны 4-р сарын 30 хүртэл 	<ul style="list-style-type: none"> • 2023 оны 1-р сарын 31 хүртэл

➤ Аль аль нь 2 долоо хоногийн хугацаа зарцуулагдана. (1) бол, өмнөхтэй адил зөвшөөрөл олгоно. (2) бол, өмнө олгогдсон агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд бусад нотлох материалыг ирүүлэхийг шаардаж магадгүй (Энэ тохиолдолд, шалгалт хийхэд тодорхой хугацаа шаардагдах болно.).

Дараах арга хэмжээ нь 2023 оны 4-р сарын 30-ны өдөр хүртэл хүчинтэй. ※ Дэлгэрэнгүйг тус бүрийн холбоосоос шалгана уу.

➤ “Байнгын оршин суугч”, “Япон улсад цагаачлагч” болон “Тусгай үйл ажиллагаа эрхлэх” статусад үл нийцэх үйл ажиллагаа эрхлэдэг хүн оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах өргөдөл мэдүүлэх боломжгүй тул, оршин суугаа газрын консулын газарт визийн мэдүүлгээ өгнө үү. (Дэлгэрэнгүйг [эндээс \(байнгын оршин суугч\)](#) эсвэл [эндээс \(“япон улсад цагаачлагч” болон “тусгай үйл ажиллагаа эрхлэх” статус\)](#) Мөн, өөр бусад оршин суух зөвшөөрөл авахыг хүсвэл, таныг төлөөлөн өргөдөл өгөх хүн байхгүй байсан ч оршин суугаа консулын газарт визний мэдүүлэг өгөх хэрэгтэй болно.